

Статистикийн хэлтэс



Багийн төвшинд албан ёсны
статистикийн үйл ажиллагаа эрхлэн
явуулахад баримтлах товч гарын
авлага

Зуунмод

2013 он

**БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРААС АЛБАН ЁСНЫ
СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭН ЯВУУЛАХ ТУХАЙ**

- I. **Нийтлэг үндэслэл**
- II. **Товч тайлбар, тодорхойлолт**
- III. **Хариуцан гаргах албан ёсны статистик мэдээ, тайлан**
- IV. **Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого**
- V. **Албан ёсны статистик мэдээний үзүүлэлтийн аргачлал, тайлбар.**
- VI. **Албан ёсны статистик мэдээ, тайланд үндэслэн гаргах судалгаа**

I.Нийтлэг үндэслэл

Албан ёсны статистикийн хүн ам, амьжиргааны түвшин, өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаа, хөдөө аж ахуй зарим мэдээний анхдагч нэгж нь баг байдаг.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ **СТАТИСТИКИЙН ТУХАЙ** (Шинэчилсэн найруулга)

1997 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, статистикийн байгууллага, мэдээлэгчийн бүрэн эрхийг тогтоож, тэдгээрийн хооронд болон хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "**статистикийн мэдээлэл**" гэж нэгдсэн хөтөлбөр, аргачлалаар цуглуулж боловсруулсан эдийн засаг, байгаль, нийгмийн холбогдолтой тоон мэдээллийг;

2/ "**статистикийн үйл ажиллагаа**" гэж статистикийн бүртгэл хөтлөх, мэдээлэл гаргаж өгөх, дамжуулах, нэгтгэн боловсруулах, тооллого, судалгаа явуулах, дүгнэлт гаргах, мэдээлэл, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тараах, хэвлэн нийтлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, сан байгуулах, хадгалахыг;

3/ "**статистикийн мэдээлэгч**" гэж статистикийн мэдээлэл, судалгаанд хамрагдсан, Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг, өмчийн бүх төрөлд хамаарагдах хуулийн этгээд,гадаадад үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын хуулийн этгээд,Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

4/ "**статистикийн мэдээллийг хэрэглэгч**" гэж статистикийн мэдээллийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа хуулийн этгээд,Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

5/ “албан ёсны статистикийн мэдээлэл” гэж Үндэсний статистикийн хорооноос баталсан аргачлал, үзүүлэлтээр энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан эдийн засаг, хүн ам, нийгэм, байгаль орчны холбогдолтой үзүүлэлтээр гаргасан мэдээлэл, статистикийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мэдээллийг;

8/ “захиргааны статистикийн мэдээлэл” гэж Үндэсний статистикийн хорооноос баталсан, зөвшөөрсөн аргачлал, үзүүлэлтээр яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэрэгцээнд зориулж цуглуулсан мэдээллийг.

11 дүгээр зүйл. Статистикийн байгууллагын тогтолцоо

2. Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ. **Суманд статистикийн үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газрын уг ажлыг хариуцсан ажилтан, баг, хороонд тэдгээрийн Засаг дарга эрхлэн гүйцэтгэнэ.** /Энэ хэсэгт 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3. Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн болон **сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан нь төрийн захиргааны албан тушаалтан** байна. /Энэ хэсэгт 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

4. Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Төсөв нь статистикийн үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна. **Статистикийн үйл ажиллагааг сум, баг, хороонд эрхлэн явуулахтай холбогдон гарах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.**

18 дугаар зүйл. Яам, Монголбанк, төрийн бусад албан газар, бүх шатны Засаг даргын статистикийн мэдээллийн талаархи нийтлэг бүрэн эрх

/Энэ зүйлийн гарчигт 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

Яам, төрийн бусад албан газар, **бүх шатны Засаг дарга** статистикийн мэдээллийн талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ албан ёсны статистик мэдээллийн үнэн зөв байдалд тогтмол шалгалт хийж, түүний бодит байдлыг хангах;

2/ статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд газар дээр нь очиж гаргуулан авах, гарсан зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;

3/ мэдээлэл, судалгааны дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх;

4/ статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос баталж, зөвшөөрсөн маягаар мэдээлэгчээс гаргуулан авах. */Энэ заалтыг 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн, 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 сарын 03 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХВН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ТУХАЙ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хвн ам, орон сууцны улсын ээлжит болон завсрын тооллого зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “**хвн ам, орон сууцны улсын тооллого**” /цаашид “тооллого” гэх/ гэж энэ хуульд заасан тооллогын хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа нийт хвн ам буюу тооллогод хамрагдах

нутаг дэвсгэр дэх хvн амыг хамруулан хvн ам зvй, нийгэм, эдийн засгийн хvрээний мэдээллийг цуглуулах, боловсруулах, нэгтгэх, дvн шинжилгээ хийх, тооллогын vр дvнг тараах цогц вйл ажиллагааг;

3.1.2.“**тооллогын тов**” гэж тооллого явуулах хугацааны эхний өдөрт шилжих шөнийн 00 цагийг;

3.1.3.“**тооллогын нэгж**” гэж хувь хvн, тvвний амьдарч байгаа байр, орон сууцыг;

3.1.4.“**тооллогын ажилтан**” гэж энэ хуулийн 13.5.2-т заасан тооллогын комиссын гишvвн, тэдгээрт гэрээгээр ажиллаж байгаа тvр ажилтныг.

4 дvгээр зvйл. Тооллого зохион байгуулж явуулах арга

4.1.Тооллого зохион байгуулж явуулахад дараахь аргыг ашиглана:

4.1.1.тооллогын хугацаанд хvн амыг нэг бvрчлэн тоолох уламжлалт арга;

4.1.2.хvн амын регистрийн бvртгэлд суурилсан бvртгэлийн арга;

4.1.3.тvвэр судалгааны арга.

5 дугаар зvйл. Тооллого явуулах зарчим

5.1.Тооллогыг дараахь зарчмаар явуулна:

5.1.1.хvн бvрийг нэг бvрчлэн тоолох;

5.1.2.тооллогын хугацаанд тооллогод хамрагдах нутаг дэвсгэрт нэгэн зэрэг тоолох;

5.1.3.тооллогын мэдээлэл нийтлэг, иж бvрэн байх;

5.1.4.тооллогыг тогтмол, давтамжтай явуулах.

Тооллого зохион байгуулж явуулах эдийн засгийн баталгаа

6 дугаар зvйл. Тооллого зохион байгуулж явуулахад гарах зардал, тvвний санхvвжилт

6.3.Тооллого зохион байгуулж явуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг орон нутгийн төсвөөс санхvвжvллнэ:

6.3.1.ажилгvй болон тэтгэвэрт байгаа хvнийг тооллогын ажилтнаар ажиллуулсан хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгох цалин хөлс;

6.3.2.энэ хуулийн 6.3.1-д заасан тооллогын ажилтнуудыг сургах сургалтын болон тооллогын талаар нутаг дэвсгэрийн оршин суугчдад хvргэх мэдээлэл, суртачилгааны зардал;

6.3.3.тооллогын хугацаанд тооллогын ажилтнуудад өгөх хоолны мөнгө;

6.3.4.хууль тогтоомжид заасан бусад зардал.

6.4.Энэ хуулийн 6.3 дахь хэсэгт заасан орон нутгийн төсвөөс санхvвжvллэх зардлын хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухай бvр тогтооно.

6.6.Энэ хуулийн 6.1.1, 6.3.1-д зааснаас бусад хvнд тооллогын ажилтнаар ажилласан хугацааны цалинг сарын дундаж цалингийн нь хэмжээгээр тооцож тухайн хvний ажилладаг байгууллага, аж ахуйн нэгж нь олгоно.

Тооллогын төрөл, хугацаа, хамрах хvрээ

7 дугаар зvйл. Тооллогын төрөл

7.1.Тооллого нь дараахь төрөлтэй байна:

7.1.1.10 жил тутамд улс орон даяар явуулах ээлжит тооллого;

7.1.2.ээлжит тооллого хооронд 5 жил тутамд явуулах завсрын тооллого.

10 дугаар зvйл. Тооллогын нэгж

10.1.Хvн амын тооллогод дараахь хувь хvнийг хамруулна:

- 10.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа Монгол Улсын иргэн;
- 10.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт 183 хоногоос дээш хугацаатай оршин сууж байгаа болон оршин суухаар эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан гадаадын харьяат иргэн, харьяалалгүй хvн;
- 10.1.3.гадаадад оршин суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, тvvний гэр бvл;
- 10.1.4.гадаадад ажиллаж, суралцаж байгаа болон хувийн хэргээр оршин суугаа Монгол Улсын иргэн.

19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хvлээлгэх хариуцлага

19.1.Тооллогын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрvvгийн хариуцлага хvлээлгэхээрvv бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

19.1.1.энэ хуулийн 16.2.2-16.2.5-д заасан vvргээ биелvvлээгvv албан тушаалтныг шvvгч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг **таваас арав дахин** нэмэгдvvлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Улаанбаатар хот

6 дугаар зүйл.Иргэний бүртгэлийн байгууллагын тогтолцоо

6.5.Хүн амын анхан шатны бүртгэл болох **хүн амын өрхийн бүртгэлийн дэвтрийг тухайн дэвсгэр нутгийн баг, хорооны Засаг дарга хариуцан хөтөлнө**

25 дугаар зүйл.Иргэн түр болон бүрмөсөн шилжин суурьших

25.1.Иргэн байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээсээ нөгөөд **180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүрмөсөн шилжин суурьших, 180 хоног ба түүнээс** доош хугацаагаар оршин **суухыг түр шилжин суурьших гэнэ.**

26 дугаар зүйл.Шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх

26.2.Иргэнийг аймаг болон нийслэлийн дотор шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар бүртгэж, мэдээлэх ажлыг хариуцна.

26.4.Иргэн аливаа засаг захиргааны нэгжид **180 хоногоос дээш хугацаагаар оршин суухдаа 10 хоногийн дотор холбогдох сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт оршин суугаа газрынхаа хаягийн бүртгэлийг иргэний үнэмлэхэд тэмдэглүүлнэ.**

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ (ЗАХИРАМЖ) ӨРХ, ХҮН АМЫН ОРЛОГО, ЗАРЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

2001 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хот Дугаар 235

Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "г"-д заасан өрх, хүн амын орлого, зарлага, хэрэглээний статистик мэдээллийг 2001 оны 11 дүгээр сарын 1-нээс эхлэн **улирал тутам гаргаж байхыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.**
2. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгах нь:

а/ өрх, хүн амын орлого, зарлагын статистик мэдээллийг гаргах аргачлал, хамрах өрхийн норматив, уг мэдээллийг гаргахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэдээлэл хүлээн авах, нэгтгэх, шалган дамжуулах орон тооны бус ажилтан буюу тоологчийн тоог тогтоох асуудлыг судалж Үндэсний статистикийн газартай хамтран баталж ажилласугай;

б/ өрх, хүн амын орлого, зарлагын мэдээлэлд хамрагдсан гэрээт өрх бүрт сард 8 цагийн, орон тооны бус ажилтан буюу тоологч нарт сард 50 цагийн хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нэг цагт ногдох хэмжээгээр тооцож улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлж байсугай;

в/ өрх, хүн амын орлого, зарлагын мэдээллийг гаргахтай холбогдсон төвлөрсөн арга хэмжээний зардлыг Үндэсний статистикийн газрын жил бүрийн төсөвт тусгаж байсугай;

3. Өрх, хүн амын орлого, зарлагын мэдээллийг улирал, жилээр нэгтгэн Засгийн газарт танилцуулж байхыг Үндэсний статистикийн газар /Ч.ДАВААСҮРЭН/-т зөвлөсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдон “Статистикийн ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1994 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 1 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР Санхүү, эдийн засгийн сайд Ч.УЛААН

"1991 оны мал тооллогыг зохион явуулах тухай" Засгийн газрын 341 дүгээр тогтоолын заалтаас:(1991 оны 11 дүгээр сарын 15 ны өдөр баталсан)

2. **Аймаг, хот, дүүрэг, сум, хороодын мал тооллогын комиссыг тухайн шатны Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны даргаар ахлуулан байгуулж, тооллогын бэлтгэл хангах, мал тооллогын ажлыг зохион байгуулах, тогтоосон хугацаанд нь явуулах.**

3. Тухайн сум, хорооны нутаг дэвсгэрт оршин суудаггүй иргэдийн (гаднын тавиул) малыг малын эзэн болон маллагч малчны хэнийх нь нэр дээр тоолох асуудлыг сум, хорооны АХГ Захиргаа шийдвэрлэж байх.

4. Мал тооллогыг явцад орон нутгийн хууль хяналт, цагдаагын байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллахын хамт, малыг тооллогоос нууж дарагдуула, бусдад тарааж өгөх, эсвэл тооллогын бүртгэлээс зөрүүлэх зэргээр улсын мал тооллогыг санаатай будлиантуулсан гэм буруутай хүмууст тухай бүр нь хуульд заасан зохих арга хэмжээ авч байхыг аймаг, хот, дүүрэг орон нутгийн хотын АДХГЗ-нд даалгажээ.

II. ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Суурин хүн ам=тухайн сумын (багийн) нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүн ам+оны эцэст сумын (багийн) нутаг дэвсгэрт байхгүй боловч 6 сарын дотор орон нутагтаа эргэж ирэх түр эзгүй хүн

Оны эхний хүн ам+(төрсөн хүүхдийн тоо-нас барсан хүний тоо)+(шилжиж ирсэн хүний тоо-шилжиж явсан хүний тоо)=оны эцсийн хүн амын тоо

Нэг өрхөд ногдох хүний тоо.Нэг өрхөд ногдох хүний тоог тодорхойлохдоо өрхөд тоологдсон хүний тоог өрхийн тоонд харьцуулна.

Б. Хүн амын ердийн хөдөлгөөн:

Төрөлтийн ерөнхий коэффициент.Энэ үзүүлэлт нь тухайн жилд 1000 хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж тооцдог.

Төрөлтийн тусгай коэффициент: Төрөх насны буюу (15-49 насны) 1000 эмэгтэйчүүдэд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг үзүүлэлт юм.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент: Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдэд харьцуулсан харьцааг хэлнэ.

Нас баралтын ерөнхий коэффициент: Нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцаа бөгөөд энэ үзүүлэлт нь 1000 хүн амд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

Насны бүлэг дэх нас баралтын коэффициент:Тухайн насны бүлэгт нас барсан хүний тоог мөн насны бүлгийн хүн амд харьцуулсан харьцаа юм.

Нялхасын нас баралтын коэффициент: Нэг хүртэл насандаа нас барсан хүүхдийн тоог тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулсан харьцаагаар илэрхийлдэг үзүүлэлт юм.

Гэрлэлтийн ерөнхий коэффициент: Иргэний гэр бүлийн байгууллагад тухайн жилд бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг “ Батлуулсан гэр бүлтэй” буюу гэр бүлтэй гэнэ.

Бүтэн өнчин хүүхэд гэдэгт эцэг, эх нь хоёул нас барсан, **хагас өнчин** хүүхэд гэдэгт эцэг, эхийн аль нэг нь нас барсан хүүхдийг бүртгэнэ. Бутач хүүхэд болон гэр бүл салалтаас болж, эцэг, эхийнхээ аль нэгэнтэй нь амьдарч байгаа эцэг, эх нь энх тунх байгаа хүүхдүүдийг өнчин гэж үзэхгүй юм.

“Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 2-т “Бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн хүүхдийг **хүнд нөхцөлд байгаа хүүхэд** гэж үзнэ”

“Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхдийг **онцгой нөхцөлд байгаа хүүхэд** гэж үзнэ”

16 хүртэл настай хүүхэдтэй, гэр бүлгүй хүний тоо-эцэг эх, хамаатан садангийн алинтай нь хамт амьдардгийг харгалзахгүйгээр бүгдийг хамруулна (эрэгтэй, эмэгтэй)
Өрх толгойлсон хүний тоо: Гэр бүлгүй өрхийн тэргүүлэгчдийн тоог хүйсээр ялгаж гаргана.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоонд хүүхэдтэй эсэхийг үл харгалзан эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийг;

Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхөд гэр бүлгүй, өрхөө толгойлон амьдарч байгаа эрэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг үл харгалзан хамруулна.

“**Тахир дутуу** хүний нийгмийн хамгааллын тухай” Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд “Бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, тарилгын дараахь хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа, сонсгол, хэл ярианы болон бие эрхтний тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг **тахир дутуу хүн** гэнэ”

Энэ хуулийн 4 дүгээр зүйл, “Нийгмийн даатгалын тухай” Монгол Улсын хуулийн 29 дүгээр зүйлд “...Тахир дутууг тухайн иргэний оршин суугаа аймаг, сум, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тахир дутууг тогтооно...”

Өрхийн зарим үзүүлэлт: Нийт өрхөөс 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрх, 16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхүүдийг тусгайлан гаргасан. Мөн өндөр настай ганц бие амьдарч байгаа 60 ба түүнээс дээш настай **эрэгтэй**, 55 ба түүнээс дээш настай **эмэгтэйг** тусгайлан, Нийгмийн даатгалын болон аж ахуйн нэгж байгууллагаас ямар нэг тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүний тоог гаргахдаа эрэгтэй 60 ба түүнээс дээш насныхныг, эмэгтэйг 55 ба түүнээс дээш насныхныг хамруулан гаргасан.

Эдийн засгийн бүсэд:

Төвийн бүс - Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцагаан, Сэргэлэн, Зуунмод

Хойд бүс - Аргалант, Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр.

Зүүн бүс - Архуст, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт, Эрдэнэ.

Баруун бүс - Баянхангай, Бүрэн, Дэлгэрхаан, Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаал, Цээл, Эрдэнэсант.

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал .

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана. Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлнэ.

Бойжилтийн хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1. **хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм** нь:

Буур - 20-25; Азарга - 12-15; Бух - 35-45; Хуц, ухна - 25-30

Малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага.

1. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

2. Хүнсний хэрэглээний малын тоо=Алдсан мал+Зах зээлд борлуулсан+Аж ахуйн дотоодод хэрэглэсэн+(Бусдад шилжүүлсэн-Худалдаж авсан, шилжиж ирсэн). Бусдад шилжүүлсэн>=Худалдаж авсан, шилжиж ирсэн

Учир нь худалдаж авсан эсвэл шилжиж ирсэн нэг хэсэг малаа идсэн байж болно. Идээгүй тохиолдолд дээрх 2 тэнцэж байх учиртай.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, бог малынхыг гаргахдаа богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлэн тэжээлийн хангамжийг гаргадаг. Үүний тулд доорхи

Хадлан өвс -	0.45 ;	Таримал тэжээл -	0.35
Даршны ургамал -	0.25;	Гар тэжээл, хужир шүү -	1.00
Төмс ногооны хаягдал -	0.22 ;	Үр тарианы хаягдал -	0.90

Лай - **0.40;** Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. **Бүдүүн тэжээл-** өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
2. **Хүчит тэжээл-** үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
3. **Шүүст тэжээл -** Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн мах, яс, цусны гурил зэрэг орно.

Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

III. ХАРИУЦАН ГАРГАХ АЛБАН ЁСНЫ СТАТИСТИК МЭДЭЭ, ТАЙЛАН

Д/Д	Мэдээ, тайлангийн нэр	Мэдээ тайлангийн		Ирүүлэх график	Жилд гаргах удаа	Хүлээн авах хэлбэр
		Маягтын №	Батлагдсан он сар өдөр			
1	Малын төллөлт, төл бойжилт	ХАА-1	1999.07.15 №119	4-7,10,1, сарын 1-нд	6	Цахим шуудан маягтаар
2	Том малын зүй бус хорогдол	ХАА-2	2002.08.05 №146	2-7, 10, 1 сарын 1-нд	8	Цахим шуудан
3	ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ	ХАА-3	2009.08.11. №120	Сар бүрийн 1- нд	12	Цахим шуудан, маягтаар
4	Жимс, жимсгэний тариалсан талбай, хураасан ургацын мэдээ	ХАА-5	2002.04.26 №82	12-р сарын 20	1	Цахим шуудан, маягтаар
5	Тариалсан талбайн мэдээ	ХАА-7	2002.04. 26. №82	5, 6, 7 сарын 1- нд	3	Цахим шуудан маягтаар
6	Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжийн тариалсан талбайн.... оны жилийн эцсийн мэдээ	ХАА-8	2002.04.26 №82	7 сарын 25	1	Цахим шуудан, маягтаар
7	Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээ	ХАА-9	2002.04. 26. №82	9,10,11 сарын 2-нд,	3	Цахим шуудан, маягтаар
8	Аж ахуйн нэгжийн хураасан ургацын эцсийн мэдээ	ХАА-10а	2002.04. 26. №82	11 сарын 10	1	Маягтаар
9	Өрх, хувиараа эрхлэх аж ахуйн хураасан ургацын эцсийн мэдээ	ХАА-10б	2002.04.26 №82	11 сарын 10	1	Цахим шуудан, маягтаар
10	Аж үйлдвэрийн сарын мэдээ	АҮ-1	2003.09.08 №176	Сар бүрийн 1	12	Маягтаар
11	Ахуйн үйлчилгээний орлогын мэдээ	АҮО-1	-	Сар бүрийн 1	12	Маягтаар
12	Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр	ХАӨБ-2	2011.09.01 №01/133	11-12 сард	1	Өрх бүрээр шинэчилнэ
13	Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн эцсийн мэдээ	НС-1	2003. № 228	12 сарын 2	1	Маягтаар
14	Суурин хүн амын жилийн эцсийн мэдээ	ХА-3	2012.07.12 №1/86	12 сарын 20	1	Маягтаар
15	Ашиглалтанд оруулсан орон сууцны хагас, бүтэн жилийн мэдээ	ОС-1	2007. № 02	7сарын 05 12 сарын 25	2	Маягтаар
16	Гэрийн фондны жилийн мэдээ	ОС-3		12 сарын 25	1	Маягтаар

IV. Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого

Олон улсын практикт тооллого нь мэдээлэл цуглуулах хамгийн түгээмэл аргын нэг билээ.

Манай улсад мал тооллогыг 1961 оноос эхлэн жил бүрийн эцэст зохион байгуулж явуулсан. Жилийн эцэст тооллого явуулах нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого зарлагын хөдөлгөөн бүрэн гарч дууссан, малчид мал бүхий иргэдийн өрх, хүн амын хөдөлгөөн харьцангуй багассан байдаг зэрэг давуу талтай юм.

Мал аж ахуйн салбар нь манай орны эдийн засгийн тулгуур, үндсэн гол салбар юм. Манай орны дотоодын нийт бүтээгдэхүүний гуравны нэгийг хөдөө аж ахуйн салбар үйлдвэрлэдэг бөгөөд үүний зонхилох хэсгийг мал аж ахуй бүрдүүлдэг. Тооллогын дүнгээс мал, амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, цаашид хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төр засгийн бодлого боловсруулан улс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд үндэслэл болдог чухал ач холбогдолтой юм.

Мал тооллогын дүн нь улс, орон нутгийн түвшинд салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн, мах, сүү, ноос, арьс, шир, өндөгний үйлдвэрлэл, мал, амьтдын өсөлт үржилтийн бүтээгдэхүүнийг тооцох үндсэн материал болдог.

Тооллого явуулах үндсэн зарчим нь:

1. Мал тооллогын ажлыг зохион байгуулж байгаа хүмүүс, тоологч нар тоолж буй мал, тэжээвэр амьтдыг нүдээр үзэж, биечлэн тоолох зарчмыг баримтлана.
2. Мал тооллогын ажлыг жил бүрийн 12 дугаар сарын 7-нд орон даяар эхэлж долоо хоногт багтаан дуусгана.
3. Мал, амьтад хаана оршиж байгаа тэр дэвсгэр нутагтаа тоологдож, тухайн нутгийн засаг захиргааны харъяаллаар данс бүртгэлд орж нэгтгэгдэх зарчмыг баримтлана.
4. Эзэн нь тодорхойгүй малыг тооллогонд бүрэн хамруулж, алдуул малын дансанд оруулна.

Мал тооллого нь жил бүр явагдаж хэвшсэн ажил боловч анхаарах зарим асуудлууд байна. Үүнд:

1. Малыг нүдээр үзэж, биечлэн тоолдог зарчим тэр бүр хэрэгждэггүй, эзнийх нь амаар тоолдог болсон, хүмүүс малынхаа тоо толгойг дарах явдал орон нутагт багагүй гарч байна гэсэн мэдээлэл цөөнгүй ирдэг.
2. Цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилдэг омгийн малыг уг төрөл үүлдэрт нь оруулж бүртгэх явдал учир дутагдалтай байдаг.
3. Малчид, мал бүхий иргэд малаа тооллогонд бэлэн байлгах, бод мал ялангуяа адуу тэмээг бэлчээрээс цуглуулж хариуллагад оруулах, оторт яваа малыг тооллогонд бүрэн хамруулж чадахгүй байна.
4. Мал төллөлт, төл бойжилт, том малын хорогдлын явцын мэдээг мал тооллогоор гарсан мэдээтэй тулгаж үзэхэд зөрөө гардаг нь (их буюу бага) тухайн шатны засаг даргын бүртгэлийг хэрхэн хөтлөдөг, ажлын хариуцлага ямар байгааг харуулдаг.
5. Тооллогын явц, тооллогод бүрэн хамрагдаж буй эсэхэд хяналтын тооллогыг тодорхой айл өрх, малд явуулах хэрэгтэй.

Ү. Албан ёсны статистик мэдээний үзүүлэлтийн аргачлал, тайлбар

1. Малын төллөлт, төл бойжилт ; том малын зүй бус хорогдол

Багийн засаг дарга нар нутаг дэвсгэрийнхээ малтай өрх, аж ахуйн нэгжийн төллөлт, малын зүй бус хорогдлын мэдээг графикт хугацаанд нь өсөн нэмэгдэх дүнгээр гаргаж мэдээлнэ.

Төллөлт, хорогдлын мэдээг гаргахдаа айл өрх бүрээр тооцоо хийх шаардлагатай байдаг бөгөөд хэрэв сарын мэдээнд бүрэн хамруулах боломжгүй /цаг агаарын хүндрэл, алс хол отроор явсан, хугацаа богино гэх мэт/ тохиолдолд байгаль цаг уур, газар зүйн ижил нөхцөлд байгаа өрхүүдээс төлөөлүүлэн хэд хэдэн өрхийн 5 төрлийн малын төл бойжилтын хувь, хорогдлын оны эхний малд эзлэх хувийг гаргаж энэ

тооцоогоороо бусад өрхүүдэд тархаан тооцсоны үндсэн дээр бүрэн мэдээлэл гаргаж байхад анхаарах хэрэгтэй.

Гэхдээ энэ тооцоог зөвхөн сарын мэдээнд ашиглаж улирлаар зайлшгүй өрх бүрээр тооцоог нарийвчлан гаргах шаардлагатай. Төллөлтийн мэдээнд гардаг гол алдаа бол төллөсөн эх, гарсан төлийн уялдаа юм. Гарсан төлийн тоо нь төллөсөн эх малын тооноос ихэр төлөөр илүү /бог малын хувьд / байна.

Малын зүй бус хорогдолд өвчний /халдвартай, халдваргүй / хорогдол, гэнэтийн аюулын / цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг /хорогдол, бусад шалтгааны/ малын хариулга, арчилгаатай. холбогдон гарсан / хорогдлыг оруулна. Гол анхаарах зүйл бол урьд сард өгсөн хорогдол дараа сард урьд сараасаа буурч болохгүй гэдгийг хатуу анхаарах хэрэгтэй .

2. Газар тариалангийн мэдээ

Сумын статистик хариуцсан ажилтан нар багуудаас тариалалт, ургац хураалтын мэдээнүүдийг графикт хугацаанд нь авч шалгаж нэгтгэнэ. Тариалсан талбайг га-аар, хураасан ургацын мэдээг бохир жингээр (ямар нэгэн хорогдол тооцоогүй) тн-оор авна.

1 га = 10000 м² = 100 сот

1 тн = 1000 кг = 10 цн

Тариалалт хийж буй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүс янз бүрийн хэмжээтэй талбайд тарьсан байдаг тул талбайн урт өргөнийг маш сайн олон дахин хэмжиж талбайн хэмжээг зөв тодорхойлох нь мэдээ үнэн гарах нөхцөл бүрдэх талтай. Тариалсан талбайг айл өрх бүрээс авахдаа заавал га, сотоор биш м²-аар авч болох бөгөөд сумын статистик хариуцсан ажилтанд өгөхдөө хэмжих нэгжийг тодорхой гаргаж өгөх хэрэгтэй. (Жишээ нь урт нь 25м, өргөн нь 15м бол нийт талбайн хэмжээ $25\text{м} * 15\text{м} = 375\text{м}^2 = 0.03\text{га} = 3.75\text{сот}$)

Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг графикт хугацаанд нь сумын статистик хариуцсан ажилтанд гаргаж өгнө. Бэлтгэсэн өвс үүнээс улсын нөөцөнд гэдэгт тухайн багийн хэмжээнд байгаль цаг агаарын хүндэрсэн нөхцөлд хэрэглэхээр тусгайлан бэлтгэж нөөцөлсөн өвсний хэмжээг тн-оор мэдээлнэ. Тариалалтын мэдээг ХАА7 маягтаар 5.6.7 сарын 1-нд мөн 6.7 сарын 14ны дотор авдаг болсон. Тариалалтын мэдээг өгөхдөө хамгийн гол хэрэглэсэн үрийг маш нарийн гаргаж өгөх хэрэгтэй. Багууд дээр гарч байгаа нэг алдаа бол хэрэглсэн үр болон усалгаатай эсэх талаарх анхаарч гаргах хэрэгтэй. ХАА8 маягтаар мэдээг гаргахдаа 8 сарын 1-нд тариалалтын эцсийн мэдээг авдаг бөгөөд үүнээс хойш тариалалтын мэдээ огт өөрчилөгдөхгүй тул тухайн гарч байгаа мэдээнд хяналт тавьж тариалалтын мэдээ айл өрх аж ахуйн нэгжийн мэдээг бүрэн хамруулах хэрэгтэй. Тухайн хугацаанд бүрэн хамруулаагүйгээс болж дараа өөрчилж нэмж оруулах гэсэн асуудал зарим сумдад гардаг тул энэ тал дээр онцгой анхаарах хэрэгтэй. Аж ахуйн нэгжийн тариалалтын мэдээг ХАА8а гэсэн маягтаар тус бүрээр авдаг, мөн өрхүүдийг баг тус бүрээр нь салгаж ХАА8а маягтаар авна. ХАА10аб маягтаар 10 сарын 25-нд сумдаас авна. ХАА10а маягтаар аж ахуйн нэгж тус бүрээр нь аваад ХАА10б маягтаар өрхүүдийг багаар нь салгаж авч байгаа 2008 оноос эхлээд өрх тус бүрээр нь тариалалт болон ургац хураалтын мэдээг авч байгаа тул эртнээс тариалалт хийсэн өрх нэг бүрээр мэдээг бүрэн хамруулах хэрэгтэй. Бас нэг анхаарах зүйл гэвэл статистик болон хөдөө аж ахуйн газрын мэдээ хоёр зарим сумдад зөрдөг бөгөөд ийм байдал гаргахгүй байх хэрэгтэй.

3. Хүн ам, нийгмийн үзүүлэлтийн мэдээ

Суурин хүн амын жилийн эцсийн мэдээ / ХА-3 /

Суурин хүн ам гэж 6 сараас дээш хугацаагаар тухайн нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа өрх, хүн амыг засаг захиргааны шилжүүлэгтэй, шилжүүлэггүйг үл харгалзан хамруулах шаардлагатай. Суурин хүн амын тоонд 6 сараас дээш хугацаагаар тухайн өрхөд байхгүй байгаа хүн буюу цэрэг, сургууль курс, гадаадад, хорих газар явсан хүмүүсийг оруулахгүй, харин 6 сараас доош хугацаагаар байхгүй байгаа хүнийг түр эзгүй гэж үзэж суурин хүн амд оруулж тооцно. Харин 0 нас гэж бүтэн нэг нас хүрээгүй байгаа өөрөөр хэлбэл 0-12 хүртэлх сартай хүүхдүүдийг хамруулж ойлгоно.

4 Багийн засаг дарга нарт зөвлөмж

Эдгээр судалгааг үр дүнтэй явуулахад багийн Засаг дарга нар гол үүрэгтэй байдаг билээ.

1.Судалгаанд сонгогдох өрхүүдийг сонгохын тулд орон нутгаас /багаас/ өрхийн жагсаалтыг бэлтгүүлэн авдаг. Энэ жагсаалт нь аймаг, сумын төвийн хувьд тооллогын нэгжийн тодорхой дугаараар /өөрөөр хэлбэл тодорхой хэсэг газрын байршлаар/, хөдөөгийн багуудын хувьд багийн нэрээр өрхийн жагсаалтыг бэлтгэнэ. Тооллогын нэгжийн дугаар, багийн нэрийг ҮСХ-ноос сонгож явуулдаг бөгөөд явуулсан хаягийн дагуу яг

тухайн хугацаанд амьдарч байгаа өрхийн жагсаалтыг бэлтгэж байх ёстой юм. Энэ жагсаалтыг бэлтгэхдээ тухайн хугацаанд амьдарч байгаа өрхийн нэрээр гаргахгүй бол /оны эхэнд байсан хуучин бүртгэлээ ашиглах гэх мэтээр бэлтгэвэл/ түүвэрлэлт алдаатай хийгдэх магадлалтай байдгийг анхаарах хэрэгтэй.

2. Статистикийн тухай хуулийн дагуу орон нутгийн ард иргэдэд албан ёсны статистик мэдээлэл болох энэ судалгааны талаар тайлбарлах ухуулах, судалгаанд ажиллаж байгаа тоологч нарт судалгааг явуулах ажилд нь бүх талын дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны (ӨНЭЗС) түүвэрлэлтээр сонгогдох өрхийн жагсаалт (ЗАГВАР)

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН НОМТ 51 ДУГААР БАГИЙН ӨРХИЙН ЖАГСААЛТ
ТҮҮВРИЙН НЭГЖИД БАЙГАА ӨРХИЙН ТОО -1151 МАЛЧИН ӨРХ 62

Өрхийн дугаар	Өрхийн тэргүүлэгчийн нэр (овгийн эхний үсэг орно)	Ам бүлийн тоо	Хаяг (Гудамж, байрны дугаар)	Малчин өрх бол (тийм=1, үгүй=2)	Тайлбар
Байрны өрх					
1	Ванчиг Бямбажав	6	10-р байр 11 тоот	2	
2	Сэнгэдорж Чимэддэлгэр	5	10-р байр 13 тоот	1	
3	Банзрагч Хүрэлбаатар	4	10-р байр 14 тоот	2	
4	Нямдондог Намхайнямбуу	2	10-р байр 15 тоот	2	
Гэр хороолол					
1	Дашдамба Эрдэнэсүх	3	1-р гудамж 11 тоот	2	
2	Тагар Мижид	3	1-р гудамж 4 тоот	1	
3	Баасанжав Батхүү	3	1-р гудамж 9 тоот	2	
Хөдөөгийн өрхийг өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуншлагын байршлаар нэг захаас нь эхлэн дараалууулан бичиж ирүүлнэ					
1	Гөлгөө Жаргалсайхан	2	Хөтөлийн бууц	2	
2	Даваа Гэрэлт-Од	3	Буутын хөтөл	2	
3	Батхүү Батаа	2	10-р-гудамж 1	2	18-р байр
4	Рэнцэндорж Доржпалам	4	жаргалан 29	2	2-р багт
5	Ганбаатар Базаррагчаа	4	7-р гудамж 6 тоот	1	5-р хороо
6	Дэмчиг Туваанжав	2	38-р байр 7 тоот		УБ амьдардаг
7	Цэнд-Аюуш Мөнхбаяр	4	11-р хороолол-1	2	түр эзгүй
8	Бадарч Отгонбаатар	2	18-р байр 23		Солонгост

2.4 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, зарлагын төрөл, байршлаар, 2012 оны 4 дүгээр улирлын байдлаар
MONTHLY AVERAGE EXPENDITURE PER HOUSEHOLD, by types of expenditure and location, as a 4th quarter of 2012

Зарлагын төрөл	Types of expenditure	Улсын дундаж National average	Нийслэл Capital city	Аймгийн төв Aimag center	Сумын төв Soum center	Хөдөө Rural area
Зарлага - Бүгд	Expenditure - Total	811 147.5	975 022.8	783 348.1	742 668.5	590 973.5
1. Мөнгөн зарлага - Бүгд	Monetary expenditure - Total	739 649.3	941 164.9	736 246.8	677 382.2	429 200.4
Хүнсний бүтээгдэхүүний зарлага	Food expenses	200 341.8	281 098.5	176 566.9	174 686.3	97 039.0
Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	Expenses on non-food items and services	446 332.4	540 093.1	474 156.0	427 781.0	269 340.2
Бусад зарлага	Other expenditure	78 923.4	109 805.7	70 105.9	57 374.1	45 159.0
Бусдад өгсөн бэлэг, тусламж	Gifts & benefits	14 051.7	10 167.6	15 418.0	17 540.8	17 662.2
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	Food and nonfood products received from others free of charge	28 003.7	29 487.2	26 399.2	17 392.0	32 365.1
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	Food consumption from own business	43 494.5	4 370.7	20 702.1	47 894.3	129 408.0

2.3 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, эх үүсвэр, байршлаар, 2012 оны 4 дүгээр улирлын байдлаар
MONTHLY AVERAGE INCOME PER HOUSEHOLD, by sources and location, as a 4th quarter of 2012

		төг / tog				
Орлогын төрөл	Types of Income	Улсын дундаж National average	Нийслэл Capital city	Аймгийн төв Aimag center	Сумын төв Soum center	Хөдөө Rural area
Орлого - Бүгд	<i>Income - Total</i>	852 266.7	1021 937.9	828 033.6	719 300.5	651 784.7
1. Мөнгөн орлого - Бүгд	<i>Monetary income - Total</i>	780 768.5	988 080.0	780 932.3	654 014.2	490 011.6
